

Өнөөгийн нөхцөлд Геологийн төв лаборатори, Мэргэжлийн хяналтын газрын төв лаборатори, төрийн болон төрийн бус 112 байгууллагын лабораторид шинжилгээ хийгдсэн байдаг боловч тус лабораторийн гаргасан акт, үнэлэлт, дүгнэлт, магадлагаа нь шүүхийн шинжилгээний арга зүйгээр хийгдээгүй шүүхэд нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх боломж байхгүй.

Түүнчлэн Манай улсад эргэлзээтэй, маргаантай шинжээчийн дүгнэлтийг нэг байгууллагаар дахин хийлгэдгээс хүндрэлтэй асуудал байнга тулгардаг.

Нэг шинжилгээг ганц байгууллага хийдэг нь олон улсын жишигт нийцэхгүй хоцрогдсон арга барил болох нь судалгааны явцад илт ажиглагдаж байна.

Иймд дээд шатны шинжилгээний төв байгууллага эсвэл мэргэжилтэн шинжээчийн профессорын орон тооны болон орон тооны бус зөвлөлийн дүгнэлтээр шийдвэрлэж болох боломжтой.

Энэ шинжээчийн зөвлөл нь чиглэл бүрийн нарийн мэргэжлийн, чадварлаг, шударга, хараат бус, орчин үеийн дэвшилтэд техник технологиор хангагдсан бие даасан, хөндлөнгийн чиг үүрэгтэй байвал зохино.

*ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын
академийн суралцагч,
цагдаагийн дэд хурандаа А.Бат-Амгалан*

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Хураангуй. Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын чиг үүрэг хамтын ажиллагааг сайжруулах арга замыг тодорхойлоход оршино.

Түлхүүр үг. Үндэсний аюулгүй байдал, хамтын ажиллагаа, хууль сахиулах байгууллага.

2010 онд шинэчилэн баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон гадаад бодлогын үзэл баримтлалд шинэ нөхцөлд аюулгүй байдлаа хангах зарчмыг хуульчилсан.

Бодлогын дээрхи баримт бичигт 1992 онд батлагдсан Монгол Улсын ардчилсан шинэ Үндсэн хуулийн үзэл санаанд тулгуурласан түүнийг хэрэгжүүлэх арга зам стратегийг тодорхойлсон.

Үзэл баримтлалд “Даяаршил улс үндэсний бусдаас хамаарах эмзэг байдлыг нэмэгдүүлж, нөгөө талаас гадаад нөөц боломжийг ашиглан

үндэсний ашиг сонирхлоо хамгаалж бататгах боломж олгож байгаа талаар тодорхой нэн оновчтой тусгажээ. Үнэхээр ч дэлхийн олон улс орон ийм нөхцөлд аюулгүй байдлаа хангах шинэ арга хэлбэрийг эрэлхийлэх нь зайлшгүй шаардлага болж байна.

Болзошгүй аюул болон эрсдлийн хүчин зүйлийн бүс нутгийн аюулгүй байдлын орчинд таагүй өөрчлөлт гарах, эдийн засаг хүмүүнлэгийн хямрал нүүрлэх, улмаар хөрш орнуудын дотоод улс төрийн нөхцөл байдал хурцдах, үндэсний эв нэгдэл, нэгдмэл байдалд нь заналхийлэх хүчин зүйлс үүсэх магадлал ойрын болон дунд хугацаанд их бишч үгүйсгэж болохгүй юм.

Монгол Улсын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх, хил хязгаарын халдашгүй дархан байдалд заналхийлэх, дүрвэгсэд болон хүн амын бусад урсгалын хөлд нэрвэгдэх зэрэг эрсдлийн хүчин зүйл гарч болохыг үгүйсгэх аргагүй юм.

Дэлхий дахины хувьд тодорхой бүс нутагт улс төрийн тогтворгүй байдал, шашин угсаатны мөргөлдөөн, иргэний дайн самуун үргэлжилсээр байх төлөв хандлага нэгэнт тодорхой болсон байна.

Дэлхий даяарыг хамарсан аюул эрсдлийн цоо шинэ хэлбэрүүд буй болж товчоор хэлбэл хөгжил дэвшил даяаршихын хэрээр аюул эрсдэл ч даяаршиж эхэлсэн. Ялангуяа сүүлийн жилүүдэд аюулгүй байдлын орчны өөрчлөлт асар хурдацтай өрнөж хэдэн арванаар тоологдох хугацаанд бус жил сар өдрөөр хэмжигдэн тасралтгүй хувирч тэр хэмжээгээр аюулгүй байдлаа хамгаалах хамтын болон шинэ арга хэрэгслүүдийг улс орнуудаас шаардах болсон нь тодорхой.

Дэлхий нийтийг хамарсан ямарч донсолгооноос аливаа улс ангид байж чадахгүй. Аливаа улсын үндэсний аюулгүй байдлын орчин шууд хаяа нийлэн орших бүс нутаг, хөрш орнууд дахь өрнөлтөөс шууд хамааралтай. Монгол Улс нэг талаасаа геополитикийн асар таатай нөхцөлд оршин тогтнож буй стратегийн түншлэлийн харилцаатай найрамдалт хоёр хөршөөр хүрээлэгдсэн энэхүү байдал бол хоёр хөршийн тогтвортой, хүчтэй төр засагтай тогтолцоо нь дэлхий дахиныг хамарсан уламжлалт бус аюул занал, тухайлбал олон улсын терроризм мөн бусад бүс нутагт гарсаар буй иргэний дайн самуун, зэвсэгт бүлэглэлүүдийн үйл ажиллагаа манай улсын хил хязгаарыг даван нэвтрэх бололцоог тодорхой хэмжээнд хааж байна.

Гадаад аюулгүй байдлын харьцангуй таатай ийм орчинд оршин тогтнож байгаа улс тийм ч олон бус. Гэвч энэ нь Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын гадаад орчин аливаа эрсдлээс бүрэн хамгаалагдсан байна гэж тайвширах үндэс болох учиргүй. Манай улсыг тойрсон бүс

нутаг улам бүр их гүрнүүдийн өрсөлдөөний талбар болох төлөвтэй байна. Монгол улсын хувьд ч эдийн засгийн өсөлт хямрал гарахын хэрээр дэлхпй нийтийн ялангуяа их гүрнүүд тэдгээрийн томоохон аж ахуйн нэгжүүдийн анхаарлыг татах болсон.

Эрдэс баялагын салбараас хэт хараат болж байгаа , төсвийн орлогын 70 хувь нь уул уурхайн салбарын буюу тодруулвал нүүрсний экспортын орлогоос бүрдэж байгаа зэргийг тооцвол дэлхий эдийн засагт савлагаа үүссэн нөхцөлд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдалд шууд нөлөөлөх хэмжээнд хүрэхээр байна. Дэлхийн эдийн засгийн аливаа хямрал, хувиралт манай улсын зөвхөн эдийн засгийн асуудал бус үндэсний аюулгүй байдлын асуудал болж хувирч байна. Аливаа улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудыг “*hard power*” буюу “хатуу хүч” хэмээн томъёолдог.

Тэрхүү “хатуу хүч”-ийг шаардлагатай цагт нь улс орныхоо тусгаар тогнол, бүрэн эрхт байдлыг хамгаалахын тулд зориулалтаар нь хэрэглэдэг. Том гүрний ийм “хатуу хүч”-ээ олон улсын тавцан дахь байр суурь нөлөөгөө бататгах, ашиг сонирхлоо хамгаалах бодлого тулган хүлээлгэхэд зориулан ашиглах нь ч бий. Болзошгүй аюулаас хамгаалах үндсэн үүргийг Монгол Улсын Зэвсэгт хүчин, хил хамгаалах албадусгай албад, тагнуул, цагдаа, онцгой байдлын ба шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба хүлээж байгаа юм.

Олон улсын энхийг дэмжих ажиллагаанд Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын тангараг өргөсөн алба хаагчдын оролцоог нэмэгдүүлэх чиглэлд баримталж буй бодлого нь аюулгүй байдлын салбарын шинэчлэл, стратеги, аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий төрийн тусгай албадын бэлэн байдал хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай,

Төрийн тусгай албад, байгуулагууд нь хамтарсан сургууль, дадлагад алба хаагчид өргөнөөр хамрагдаж, команд-штабын болон хээрийн сургуулийн түвшинд оролцоогоо нэмэгдүүлэх нь тэдний мэргэжлийн ур чадвар олон талт үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг нь дээшлүүлэх чухал ач холбогдолтой.

Энэ чиглэлээ үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд алба хаагч нар өөр өөрсдийн хуримтлуулсан туршлагаас суралцах давуу талтай юм. Нэг улс дангаараа тэмцэж хүчирэхгүй ийм олон төрлийн шинэ аюул эрсдэлтэй нэг улсын доторхи аюулгүй байдлын салбарын байгууллагууд бидний томъёолдогоор “хүчний” гэх байгуулагууд дан ганцаараа тэмцээд амжилтанд хүрэхгүй нь тодорхой.

Шинээр үүссэн аюул эрсдэлтэй тэмцэхэд төрийн тусгай албад, байгууллагуудын хамтын ажиллагаа ч хангалтгүй, төр иргэний хамтын ажиллагаа нэн чухал байна.

Тиймээс ч үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Иргэдээ аюулгүй байдлын асуудлаар өргөн мэдээлэл мэдлэгтэй байх, аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт хувь нэмрээ оруулах боломжоо хангах хамтран ажиллахад төр онцгой анхаарна” гэж тусгасан.

Манай иргэд хил дамнасан хар тамхи, мансууруулах бодисын зохион байгуулалттай наймааны золиос төдий байхаа нэгэнт больж, гүйцэтгэгч оролцогчийн хэмжээнд яригдаж байна. Аюулгүй байдлын эрсдэлүүдийг тооцож тэдгээртэй тэмцэж чадаагүй улс засаглалын хомсдолд орж, энэ буурин дээр хууль бус наймаанаас эхлээд терроризм, зэвсэгт мөргөлдөөнд хүртэл хүргэдэг гашуун сургамж байдаг.

Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагууд механик нэгдлээр биш, бодлогын үйл ажиллагааны сургалт дадлага, байнгийн бэлтгэлийн нэгдлээр салбар байгууллага хоорондын эв нэгдлээр нэгдэн нийлж ажиллах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Хил орчмын нутаг дэвсгэрт хүн, мал тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихсэж үйлдэгдэж байгаа хэрэг зөрчил буурахгүй гадаад улсаас манай улсруу хандах хандлага их болж цаашдаа эрүүгийн нөхцөл байдал хүндэрч үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хандлага үүсч болзошгүй. Хил орчмын бүс нутаг дэвсгэрт болзошгүй гэмт халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор чиг үүрэг бүхий байгууллагуудыг татан оролцуулсан дадлага сургалтыг зохион байгуулж мэргэжлийн албадыг чадвахижуулж байх нь хилийн аюулгүй байдлыг хангах хүн хүч техник хэрэгслийн хуваарилалт чиг үүргийг тодорхойлсон албаны бэлэн байдалд ажиллах “*Нэгдсэн стандарт*”-ыг гаргаж мөрдөж, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах хэрэгтэй.

Төр, орон нутгийн удирдлагаас үндэсний аюулгүй байдалтай холбогдолтой, гарч болзошгүй нөхцөл байдалд ажиллах шийдвэрийг бүх шатны байгууллага, албан тушаалтан, иргэдийн түвшинд шуурхай авч хэрэгжүүлэх нөхцөл боломж бүрдэнэ гэж дүгнэж байна.